



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/162

Мандагловь

“Сонголт Дизайн” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/71 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Сумдын ерөнхий төлөвлөгөө боловсруулах /Хулд, Луус/” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Сонголт дизайн” ХХК-тай 176,800,000 (нэг зуун далан зургаан сая найман зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан ажлын даалгаврын дагуу Хулд, Луус сумдын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Сонголт Дизайн” ХХК-ний захирал (Я.Сумхүү)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Хулд сумын Засаг дарга (П.Бямбалхагва), Луус сумын Засаг дарга (Б.Өлзийхишиг), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ



486217718